



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян дахь
сум дундын эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/67/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор: Э.Энхцэцэг Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn Аудитор: Б.Ариунбаатар Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: domogovi@audit.gov.mn

2021.02.24 № 1-6/101

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД
СУМЫН ЗҮҮНБАЯН ДАХЬ СУМ ДУНДЫН
ЭМНЭЛГИЙН ЭРХЛЭГЧ Ц.БОЛОРМАА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян дахь сум дундын эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян дахь сум дундын эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

0100200037

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	54.1	282.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	733.9	777.8
	Нийт хөрөнгийн дүн	788.0	1,060.2
	Нийт өр төлбөрийн дүн	0.0	0.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	788.0	1,060.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	788.0	1,060.2
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	495.9	1,123.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	473.6	851.5
	Үйл ажиллагааны үр дүн	22.3	272.2
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	22.3	272.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	788.0	788.0
	Тайлант оны үр дүн		272.2
	Эцсийн үлдэгдэл	788.0	1,060.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	437.3	720.4
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	430.0	669.4
	Үйл ажиллагааны ЦМГ	7.3	50.9
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(7.3)	(32.3)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	18.6
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	18.6
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		555.1
	Урсгал зардал		555.1
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		573.7
	Улсын төсвөөс санхүүжих		489.9
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		60.1
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		23.8

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян дахь сум дундын эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
- Дэмжих үйлчилгээ

Эрхэм зорилго: Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян дахь сум дундын эмнэлгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг стандартын түвшинд аюулгүй, чанартай, хүртээмжтэй, шуурхай үзүүлэхэд оршино.

Дотоод хяналтыг тогтмол төлөвлөгөө гарган графикийн дагуу хийж хэвшсэнээр эмнэлгийн тусламж үйлчилгээ, халдвар хамгаалал, архив бичиг хэрэг, санхүүгийн үйл ажиллагаа тушаал зааврын дагуу чанартай явагдаж байгаа бөгөөд өмнөх жилүүдийн магадлан итгэмжлэлд орж хангалттай үнэлгээ авсан болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Ковид-19 цар тахал өвчинтэй холбоотой засгийн газрын тогтоол, шийдвэрүүд шинээр гарч хэрэгжсэн.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

ЭМЯ-ны 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 4/422 тоот албан бичгийн дагуу эрүүл мэндийн салбарт санхүүжилтийн шинэчлэлийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь 2021 оноос эхлэн гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг авч эхэлсэн байна. Мөн тайлант онд тус байгууллагын үндсэн харилцах дансны 18.6 сая төгрөг, нэмэлт харилцах дансны 0.02 сая төгрөгийн ийн үлдэгдлийг төвлөрүүлээгүй мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнасан байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 146 мэдээллийг хугацаандаа оруулсан, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 3.6 сая төгрөгийн 4 алдаа илэрснийг залруулав.

Залруулсан алдаа:

1. Тайлант онд Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй авсан 40.0 мянган төгрөгийн нэгжийг орлогод аваагүй байсныг залруулав.

2. Үндсэн хөрөнгийн элэгдлийг 3.4 сая төгрөгөөр илүү бодуулсныг залруулав.

3. Махны зарцуулалтыг шаардах хуудасны дүнгээс 34.8 мянган төгрөгөөр дутуу зарлагадсан байсныг залруулав.

4. Эм боох материалын дансанд бүртгэгдэх 179.4 мянган төгрөгийн материалыг аж ахуйн материал болон бусад хангамжийн материалын дансанд бүртгээснийг холбогдох дансанд бүртгүүлэн залруулав.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян дахь сум дундын эмнэлэг	1	1	-	-	1	-	-	-
НИЙТ									

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян дахь сум дундын эмнэлэг	4	3.6	4	3.6	-	-	-	-	-	-
НИЙТ		4	3.6	4	3.6	-	-	-	-	-	-